



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А-98

Улаанбаатар хот

Төв банкнаас зээл, санхүүжилт олгоход барьцаалах
хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны
жагсаалтыг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15 дугаар зүйл, 20¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг Төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалтыг шинэчлэх тухай саналыг тодорхой нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг харгалзан тухай бүр боловсруулж, танилцуулахыг Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул)-нд даалгасугай.

3.Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул), Тайлан бүртгэлийн газар (Ц.Гарьд)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-262 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2020 оны 3 дугаар сарын 23-ий өдрийн
А-98 дугаар тушаалын хавсралт



**ТӨВ БАНКНААС БАНКИНД ЗЭЭЛ, САНХҮҮЖИЛТ ОЛГОХОД БАРЬЦААЛАХ
ХӨРӨНГӨ БОЛОН ХУДАЛДАН АВАХ ҮНЭТ ЦААСНЫ ЖАГСААЛТ**

1. Төв банкнаас зээл, санхүүжилт олгоход дараах төрлийн активыг барьцаа хөрөнгөд авна.
Үүнд:

Зээл, санхүүжилтийн төрөл	Барьцаа хөрөнгө ¹
1. Нээлттэй захын үйл ажиллагаа	
1.1 Репо арилжаа	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Эрдэнэс Монгол ХХК-иас гаргасан Хөгжлийн банкны баталгаатай Эрдэнэс бонд, МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд
2. Санхүүжилтийн байнгын хэрэгсэл	
2.1 Репо санхүүжилт	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Эрдэнэс Монгол ХХК-иас гаргасан Хөгжлийн банкны баталгаатай Эрдэнэс бонд, МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд
2.2 Өдрийн репо хэлцэл	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас
3. Барьцаат зээл	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Монгол улсын Хөгжлийн банкны үнэт цаас, Хөгжлийн банкны баталгаатай Эрдэнэс Монгол ХХК-иас гаргасан Эрдэнэс бонд, МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд, банкны хэвийн зээл

2. Төв банкны барьцаа хөрөнгийн эрсдэлийн хямдруулалтын хэмжээ, хувиар

2.1 Тогтмол купонтой үнэт цаасны эрсдэлийн хямдруулалт:

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (Барьцаа хөрөнгийн үлдэгдэл хугацаа)					
	0-1 жил	1-3 жил	3-5 жил	5-7 жил	7-10 жил	10+ жил
Төв банкны үнэт цаас	0.5	1.0	1.5	2.0	3.0	5.0
Засгийн газрын үнэт цаас	0.5	1.0	1.5	2.0	3.0	5.0
Хөгжлийн банкны үнэт цаас	1.0	1.5	2.5	3.5	4.5	8.0
Эрдэнэс бонд	40					
Давуу эрхтэй ИЗББ	30					
Энгийн эрхтэй ИЗББ	50					

2.2 Купонгүй үнэт цаасны эрсдэлийн хямдруулалт:

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (Барьцаа хөрөнгийн үлдэгдэл хугацаа)
-----------------	---

¹ -Барьцаанд авах аливаа төрлийн үнэт цаас нь ҮЦТХТ ХХК-д бүртгэлтэй, биет бус үнэт цаас байна.

	0-1 жил	1-3 жил	3-5 жил	5-7 жил	7-10 жил	10+ жил
Төв банкны үнэт цаас	0.5	2.0	2.5	3.0	4.0	7.0
Засгийн газрын үнэт цаас	0.5	2.0	2.5	3.0	4.0	7.0
Хөгжлийн банкны үнэт цаас	1.0	2.5	3.5	4.5	6.5	10.5

2.3 Банкны хэвийн зээлийн эрсдэлийн хямдруулалт:

Зээлийн үлдэгдэл хугацаа	Эрсдэлийн хямдруулалт
3 жил хүртэл	30
3 жилээс дээш	50